217

# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1994 оны 6 сарын 09 өдөр

Дугаар А-189

Улаанбаатар хот

Статистикийн хэлтсийг байгуулж, Эдийн засаг нийгмийн бодлогын хэлтсийн дүрмд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах тухай

I.Монгол улсын Засгийн газрын I994 оны 5 дугаар сарын II-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 5 дугаар заалтыг үндэслэн нийслэлийн Засаг даргын Тамгын газарт I994 оны 7 дугаар сарын I-нээс Статистикийн хэлтэс байгуулж ажиллуулсугай.

2.Статистикийн хэлтсийн дүрмийг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

3.н.Вандангийн Очирпүрэвийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтсийн даргаар I994 оны 7 дугаар сарын I-нээс томилж үндсэн цалинг цалингийн нэгдсэн сүлжээний Б-7 ангилалд заасны дагуу I7600 төгрөгөөр тогтоон I994 оны 7 дугаар сарын I-нээс олгохыг Тамгын газар /н.Болдсайхан/-т зөвшөөрсүгэй.

4.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтэцэд өөрчлөлт орсонтой холбогдон нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг,нийгмийн бодлогын хэлтсийн дүрмийг хоёрдугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын I993 оны II дүгээр сарын 04-ний А/244 дүгээр захирамжийн 5 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА Д.БААСАНЖАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Статистикийн хэлтэс нь нийслэлийн нутаг дэвсгэр дээр статистикийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Статистикийн хэлтэс нь үйл ажиллагаандаа статистикийн тухай хууль, засаг захиргааны хариуцлагын хууль, нягтлан бодох бүртгэлийн хууль, аж ахуйн нэгжийн хууль, болон бусад хуулиуд, хэлтсийн дүрэм, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоол, шийдвэр, нийслэлийн засаг даргын захирамж, статистикийн төв байгууллагын даргын тушаал, зааврыг удирдлага болгон ажиллана.

1.3. Статистикийн хэлтэс нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээгээр статистикийн албан ёсны мэдээллийг дээд байгууллагаас тогтоосон хугацаанд статистикийн төв байгууллагад дамжуулах, мэдээ тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах, статистикийн нэлэнхүй болон түүвэр судалгаа, тооллого явуулах, дүнг танилцуулах, дүүргийн статистикийн албадыг аргачлал арга зүй, заавар, удирдлагаар хангах, нийслэлийн нутаг дэвсгэрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний програм хангамж, тооцоолох техникийн ашиглалтыг сайжруулах зэрэг нийслэлийн засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.4. Статистикийн хэлтэс нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогчид, Тамгын газрын өдөр тутмын, статистикийн төв байгууллагын мэргэжлийн удирдлагын дор ажиллаж тэдгээрт ажлаа хариуцан тайлагнана.

1.5. Статистикийн хэлтсийн даргыг статистикийн төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Нийслэлийн засаг дарга томилж албан тушаалаас чөлөөлнө.

1.6. Статистикийн хэлтсийн дарга нь эрх хамжааний асуудлаар тушаал гаргана.

1.7. Статистикийн хэлтэс нь Нийслэлийн засаг даргын Тамгын газраас тогтоосон журмын дагуу нэгдсэн тэмдэг, Албан бичиг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Статистикийн хэлтсийн үүрэг

2.1. Статистикийн хуулийн болон статистикийн төв байгууллагаас тогтоосон журмын дагуу албан ёсны мэдээ тайлан, хүн, малын болон бусад тооллого, судалгааг явуулж дүнг төвд мэдээлэх, нийслэлийн засаг даргаас нутаг дэвсгэрийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх албан ёсны төвлөрсөн бус мэдээллийг статистикийн төв байгууллагаар хянан зөвшөөрүүлж мөрдүүлэн мэдээ тайланг нэгтгэн судалгаа дүгнэлт хийж танилцуулах.

албан ёсны статистикийн мэдээллийн үндсэн үзүүлэлтийг нутаг дэвсгэрийн хэмжээгээр гаргаж өгөх.

2.2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдлыг сар бүр нэгтгэн дүгнэх, нийслэлийн удирдлага болон салбар хэлтсийг статистикийн шаардлагатай тоо материал, судалгаагаар хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон түмэнд мэдээлэх.

2.3. Нийслэл хотын хэмжээгээр эдийн засаг нийгмийн үндсэн үзүүлэлтүүдээр олон жилийн эрэмбүүлэлт хийж, тоон мэдээллийн санг бий болгох.

2.4. Хот болон дүүргийн статистикийн албадын ажлыг механикжуулах, автоматжуулах, телехолбоонд оруулах, техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах.

2.5. Нийслэл хотын мэдээллийн автоматжуулалт, мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, нэгдсэн сүлжээнд хэрэглэгчийн цэгийг холбох, хот дүүргийн статистикийн болон бусад хэлтэс тасгийн ажилтанд компьютерийн мэдлэг боловсролыг эзэмшүүлэх, дээшлүүлэх.

2.6. Дүүргийн статистикийн албадыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний статистикийн мэргэжлийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх.

2.7. Статистикийн тухай хуулийг нийслэл хотын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийн байдлыг хянан үзэж илэрсэн дутагдлыг арилгах.

2.8. Мэдээлэгчидээс нууцлахыг хүссэн үзүүлэлт, мэдээллийн нууцыг чандлан хадгалах.

Гурав. Статистикийн хэлтсийн эрх

3.1. Статистикийн тухай хуульд заасан нийслэлийн засаг даргын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үүнд:

а) Нийслэлийн нутаг дэвсгэр дээр байрлах үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй өмчийн бүх хэлбэрийн улсын үйлдвэрийн газар, компани хоршоо, ХЗАА болон Монгол улсын, гадаадын харьяат, харьяалалгүй иргэд (мэдээлэгч)-ээс мэдээллийг дээд байгууллагаас тогтоосон хугацаанд нь дүүргийн статистикийн албадаар дамжуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийх, ашиглах, мэдээлэх, нийслэлийн удирдлагад гаргаж өгөх, танилцуулах.

б) Статистикийн төв байгууллагаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу бүх төрлийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах.

в) Нийслэлийн засаг дарга, орлогчид, салбарын хэлтэс, тасгуудын үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг албан ёсны статистикийн мэдээллийн ижил үзүүлэлттэй давхардуулалтгүйгээр бий болгож мэдээлэгчидээс авах.

г) Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд болон бусад үзүүлэлтүүдээр мэдээллийн нэгдсэн сан байгуулах.

д) Дүүрэг, хороодын засаг даргыч статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх, аргачлалаар хангах, хяналт тавих.

е) Статистикийн мэдээ тайлангийн нийт үзүүлэлтийг боловсронгуй болгох талаар саналаа статистикийн төв байгууллагад тавих.

ё) Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал, цаг үеийн ажлын талаар радио, телевиз, хэвлэлд мэдээлж нийтлүүлэх.

ж) Дүүрэг, хороодын статистикийн ажилтнаас Улсын статистикийн байцаагчаар томилуулах саналаа статистикийн төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

з) Статистикийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд статистикийн төв байгууллагаас батлаагүй буюу зөвшөөрөгдөөгүй статистикийн мэдээ тайланг давхардуулан авах ажиллагааг зогсоох.

к) Мэдээлэл тооцооны боловсруулалтын ажлын түвшин, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор тооцоолох техник, хэрэглэл тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх үндсэн дээр, тооцоо захиалгыг боловсруулах, хэрэгжүүлэх, нэвтрүүлэх.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

1994.6.7

Нийслэлийн Засаг даргын 1994 оны
6-р сарын 29-ны өдрийн А-109 тоот
захирамжийн 1-р хавсралт.

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс нь нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын зангилаа асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн удирдлага, төлөвлөлт, үнэ, зах зээлийн харилцааг зохицуулах, хүн ам, хөдөлмөрийн нөөц, хөдөлмөр хамгаалал, нийгмийн халамж, нийгэм хангамжийн болон залуучуудын асуудалтай холбогдсон ажлыг нутаг дэвсгэр, харьяаллын хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэг бүхий нийслэлийн засаг захиргааны байгууллагын нэгж мөн.

1.2. Энэ хэлтэс нь Залуучуудын тасагтай ажиллах бөгөөд Засаг даргын Тамгын газрын өдөр тутмын болон Монгол улсын Засгийн газрын дэргэдэх Үндэсний хөгжлийн газар, Хүн ам зүйн бодлого, хөдөлмөрийн яамны мэргэжлийн удирдлагын дор ажиллаж, Засаг даргын Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.3. Залуучуудын тасаг нь түүс хэлтсийн дүрмийг баримтлан ажиллах бөгөөд мэргэжлийн ажлын хувьд тасгийн зохион байгуулалтад, дотоод ажлын хувьд хэлтсийн зохион байгуулалтад хамрагдана.

1.4. Хэлтэс нь эрх хэмжээнийхээ хүрээнд багтах асуудлаар тушаал гаргана.

1.5. Хэлтэс нь нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс, Нийгэм хангамжийн хэлтэс, Хөдөлмөрийн бирж, залуучуудын асуудал хариуцсан ажилтай хэлтэсгүй дүүргийн хувьд эдгээр асуудлыг хариуцсан ажилтнуудын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавих.

1.6. Хэлтэс нь тэмдэг, тусгай хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.7. Хэлтэс, тасгийн даргыг ажилд томилох, чөлөөлөх асуудлыг Засаг дарга шийдвэрлэнэ. Хэлтэс, тасгийн бусад ажилтныг хэлтэс, тасгийн даргын саналыг үндэслэн хотын Засаг даргын Тамгын

газрын даргын тушаалаар ажилд томилох буюу чөлөөлнө.

## Хоёр. Эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаарх хэлтсийн үүрэг

2.1.Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн болон жилийн чиглэл, хөгжлийн төслүүдийг нэгтгэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.2.Зах зээлийн харилцаанд нийслэл хотыг шилжүүлэх, аж ахуйг хөтлөн удирдах арга хэлбэрийн талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах.

2.3.Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжил, хүн ам, хөдөлмөрийн нөөц нийгэм хангамж, нийгмийн халамжийн асуудалтай холбогдолтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа, тооцоо, мэдээллийг гаргаж, холбогдох арга хэмжээ авч байх,

2.4.Нийслэлийн эрх хэмжээний хүрээнд үнийн бодлогыг зах зээлийн механизм, эрэлт хэрэгцээтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх, зарим бүтээгдэхүүний үнэ, ажил үйлчилгээний тарифыг хянан бүртгэх нутаг дэвсгэрийн хэмжээнд үнийн хяналтыг зохион байгуулах,

2.5.Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын лимит, хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох газартай хамтран шийдвэрлүүлж байх хуваарилалт, хөрөнгө оруулалтын үр ашигт судалгаа дүгнэлт хийх,

2.6.Нийслэлийн хэмжээнд чанарын болон стандарт хэмжил зүйн журам биелүүлэх ажлыг зохион байгуулах,

2.7.Хувийн хэвшлийн аж ахуйг дэмжиж хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх.

2.8.Нутаг дэвсгэрт байрлах өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүд, төсөвт байгууллагуудын ажлын эрчимийн үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд уялдуулан зохицуулах,

2.9.Эдийн засаг, нийгэм, экологи, шинжлэх ухаан, техник, хүн ам зүйн бодлого, хөдөлмөрийн тодорхой асуудлаар төсөл боловсруулж хэрэгжүүлэх, зуучлах, зохион байгуулах,

2.10.Улаанбаатар хотод төрийн өмч хувьчлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын явцад нь санал дүгнэлт өгөх,

2.11."Хүн" хөтөлбөрийн хүрээнд гэр бүл болон хувь хүний бүх талын хөгжлийг хангахад чиглэсэн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх,

2.12.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх, ажилгүйдлийг багасгах, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг оновчтой шийдвэрлэх, хөдөлмөр хамгааллын талаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх, хяналт тавих,

2.13.Иргэдийн санал хүсэлт, мэргэжил чадварыг харгалзан зохих гэрээ хэлцэл, нөхцөл, дээд байгууллагын шийдвэрийн үндсэн дээр тодорхой хугацаагаар гадаадад хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг удирдан зохион байгуулах,

2.14.Монгол улсын тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шийтгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах,

2.15.Тэтгэврийн сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, нийслэлийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулна.

2.16.Бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, материалын бүрдлийн үнэлгээлэлд санхүүгийн баримтын шалгалтыг графикийн дагуу тогтмол хийж зөрчлийг арилгуулах,

Гурав.Залуучуудын асуудал эрхэлсэн
тасгийн үүрэг

3.1.Монгол улсын Хүн амын бодлого хөдөлмөрийн яамны Залуучуудын бодлогын газар болон холбогдох бусад газраас залуучуудтай холбогдуулан гаргасан шийдвэрийг нутаг дэвсгэрийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

3.2.Нийслэлийн залуучуудын чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх асуудал, тэдний дунд зохиох ухуулга сурталчилгаа, олон нийтийн ажлын талаар төр захиргаа, олон нийт, залуучуудын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх, хамтран ажиллах,

3.3.Залуучуудын сургалт болон залуучуудын холбогдолтой судалгааны ажлын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

3.4.Залуучуудын олон нийтийн болон үүсгэл санаачлагын байгууллага хөдөлгөөний ажлыг дэмжин, хамтран ажиллах,

3.5.Нийслэлийн төр/ захиргааны байгууллагаас гарах тогтоол шийдвэрт шаардлагатай нөхцөлд залуучуудын эрх ашигтай холбогдсон асуудлыг тусгах,

Дөрөв.Эдийн засаг, нийгмийн бодлогын
хэлтсийн эрх

4.1.Хотын эдийн засаг, нийгмийн амьдралтай холбогдолтой асуудлаар санал боловсруулж, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллагуудад оруулах,

4.2.Төлөвлөгөө, үндсэн чиглэл, хөгжлийн төсөл, хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой асуудал боловсруулахад шаардагдах судалгаа, тооцоо,мэдээ тайлан зэрэг материалыг дүүргийн Засаг даргын Тамгын газар, хотын харьяа байгууллага, хэлтэс нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авах/ дээрх чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах, судалгаа тооцоо хийх зэрэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах,

4.3.Хотын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн төвлөрөлт, хөрөнгийн зориулалтын дагуу хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнд оруулах өөрчлөлт, зохицуулалт болон хотод баригдах бүх төрлийн барилга байгууламжийн газар олголтын асуудалд санал өгөх,

4.4.Хэлтсийн эрхлэх бүх асуудлаар семинар, зөвлөлгөөн, сургалт зохион байгуулах,

4.5.Төлөвлөгөөний хэрэгжилт, үнэ, тарифын мөрдөлтийн байдлыг хот, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, харьяа газрууд,

нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгжүүдэд шалган зааварлах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргуулан авах,

4.6.Засгийн газрын 1991 оны 262 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм"-д заасан улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийн хэмжээнд ажиллах,

Тав.Залуучуудын тасгийн эрх

5.1.Дүүргийн Засаг даргын Тамгын газар, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас эрхэлсэн ажлын холбогдолтой мэдээ, материалыг гаргуулан авах, үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь хангуулна.

5.2.Залуучуудын эрх ашгийг хохироосон үйл ажиллагаа явуулсан буюу тогтоол шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг өөрчлүүлэх, хүчингүй болгуулах буюу арга хэмжээ оногдуулах саналаа холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

5.3.Залуучуудын төлөө үйлсэд идэвхи зүтгэл гаргасан хүмүүс, хамт олон, байгууллагыг шагнаж урамшуулах талаар холбогдох байгууллагад санал оруулах,

5.4.Нийслэлийн залуучуудын тулгамдсан асуудлаар болон залуучуудын холбогдолтой ажлын талаар радио телевиз, хэвлэлээр сурталчлах,